



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/334

Мандалговь

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "г", Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.3, 7.1.5, 7.1.6, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 02-ний өдрийн 13 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад боловсролын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан бэлтгэсэн Дундговь аймгийн Сайнцагаан сумын "Хүмүүнлэг" сургуулийн нийгмийн ажилтан Н.Мөнхцэцэгийн "Дурсамжийн цэцгээс эрих" номын хэвлэлийн зардалд 500.000 (Таван зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зардалд шаардагдах 500.000 (Таван зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210972